

КОМПАНИЙН ТУХАЙ

Байгуулагдсан: 1994
ХК болсон: 2018

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД	%
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	45.7%
Бодь Даатгал ХК	3.4%
С.Оргил	4.7%
Г. Бат-Эрдэнэ	4.7%
Н.Мөнхнасан	4.6%
Бусад	36.9%

Менежмент:

Гүйцэтгэх захирал: Н.Эрдэнэтулга
20+ жилийн туршлага

Гүйцэтгэх удирдлагын баг:

10 гишүүн
10+ жилийн туршлага

Ажилчдын тоо: 104 гаруй

Эрэгтэй 33%, Эмэгтэй 77%

ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ХАРЬЦААНУУД

ХАРЬЦААНУУД	2023	2024
Өөрийн хөрөнгийн өгөөж ROE (%)	18.6%	10.9%
Нийт хөрөнгийн өгөөж ROA (%)	8.2%	4.3%
Хосолсон Харьцаа	97.0	98.3
Зардлын Харьцаа	55.6	49.5
Хохиролын Харьцаа	41.4	48.7
Цэвэр Ашгийн Маржин	10.1%	4.53%

ОНЦЛОХ МЭДЭЭЛЛҮҮД

- Ард Даатгал ХК Төрийн Банктай хамтарч ипотек болон амины орон сууцны зээлд зориулсан "Баталгааны даатгал"-ын шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд энэхүү бүтээгдэхүүн нь иргэдэд ипотекийн зээлд илүү хялбараар хамрагдах боломжийг бүрдүүлнэ. Одоо байгаа тогтолцоогоор ихэнх хүмүүс урьдчилгаа төлбөргүйн улмаас ипотекийн зээлд хамрагдах боломжгүй байгаа бөгөөд "Баталгааны даатгал" нь энэхүү асуудлыг шийдэх гол шийдэл нь болох юм. Мөн ипотекийн зээлийн эрэлттэй уялдаж баталгааны даатгалын үйлчилгээ нь жолоочийн хариуцлагын даатгалын дараа орох хамгийн өндөр эрэлттэй бүтээгдэхүүн болох магадлалтай байна.
- Даатгалын салбарын анхны тогтвортой хөгжлийн тайланг гаргав.
- Компанийн хураамжийн орлого болон нийт хөрөнгө өсөж байгаа хэдий ч үнийн өсөлттэй холбоотойгоор дундаж нөхөн олговрын хэмжээ нэмэгдсэнээс гадна 2024 онд зудын эрсдэлтэй холбоотой ХАА-н салбар дахь нөхөн төлбөрийн хэмжээ өссөн нь цэвэр ашиг буурахад тус тус нөлөөлсөн.

2025 ОНЫ ЗОРИЛТ

- Цахим архиваа сайжруулж, онлайн даатгалын үйлчилгээг улам хялбараар авах боломжийг бүрдүүлнэ.
- Ард Даатгал ХК нь 70 гаруй компанитай хамтран ажилладаг нь салбартаа тэргүүлэх үзүүлэлт бөгөөд энэ онд хамтран ажиллагч байгууллагуудын тоог улам нэмэгдүүлнэ.
- Мэдээлэл болон үндсэн үйл ажиллагааны ISO стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

ТОГТВОРТОЙ ӨРГӨЖИН ТЭЛЖ БУЙ ДААТГАЛЫН КОМПАНИ

Ард Даатгал ХК нь 1994 онд үүсгэн байгуулагдсан Монголын ууган даатгалын компаниудын нэг бөгөөд 2018 онд олон нийтэд нээлттэй компани болсон. Ард Даатгал нь эрүүл мэнд, жолоочийн хариуцлага, эд хөрөнгийн гэх мэт бүх салбарт даатгалын үйлчилгээ үзүүлэхээс гадна уул уурхайн хүнд даацны машин, механизм, ачаа тээвэр, ажил олгогчийн хариуцлагын гэх мэт салбарын нарийн үйл ажиллагаанд зориулсан даатгалын үйлчилгээг мөн үзүүлдэг. Түүнчлэн 2024 онд Ард Даатгал нь Тендерийн баталгааны даатгалын үйлчилгээ нэвтрүүлсэн нь салбарын хувьд онцлох үйл явдал болсон юм. Ард Даатгал компанид 2024 оны байдлаар 256,512 харилцагч даатгуулсан бөгөөд энэ өнгөрөгч онтой нь харьцуулбал 5%-р өссөн үзүүлэлт юм.

ДААТГАЛЫН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол улсад 2024 оны байдлаар ердийн даатгалын 17, урт хугацааны 2, давхар даатгалын үйлчилгээ үзүүлэгч 1 компани байна. Олон улсад даатгалын салбарын хөгжлийг даатгалын гүнзгийрэл буюу салбарын хураамжийн орлогыг ДНБ-тэй харьцуулсан харьцаагаар хэмждэг бөгөөд МУ-ын хувьд энэ үзүүлэлт 11 дахин бага байгаа нь энэ салбарт цаашид тэлэх орон зай их байгааг харуулж байгаа юм. Түүнчлэн хүртээмжийн үзүүлэлт буюу даатгалын нягтрал жил ирэх тусам өсөж байгаа бөгөөд гэрээний тоо болон даатгалын хураамж мөн адил өсөх төлөвтэй байна.



Санхүүгийн голлох үзүүлэлтүүд

сая ₮	2022	2023	2024	YoY%
Нийт хөрөнгө	35,645	44,156	51,133	16%
Өр төлбөр	4,261	3,571	4,626	30%
Нөөц сан	14,704	22,367	26,912	20%
Нийт эздийн өмч	16,679	18,218	19,595	8%

Орлогын бүтэц

сая ₮	2022	2023	2024	YoY%
Нийт хураамжийн орлого	22,316	32,438	45,244	39%
Давхар даатгал	(4,231)	(5,660)	(7,150)	26%
Буцаасан даатгал	(469)	(828)	(1,294)	56%
Цэвэр хураамжийн орлого	17,616	25,950	36,800	42%
Орлогод тооцсон хураамж	15,016	20,147	33,610	67%
Нийт нөхөн төлбөр	(7,859)	(14,095)	(19,663)	39%
Давхар даатгалаас	255	3,804	931	-76%
Буруутай этгээдээс	1,574	1,951	2,394	23%
Цэвэр нөхөн төлбөр	(6,030)	(8,341)	(16,338)	96%
Хөрөнгө оруулалтын олз/гарз	436	3,145	1,316	-58%
Үйл ажиллагааны зардал	(8,958)	(11,202)	(11,691)	4%
Татвар төлөхийн өмнөх ашиг	903	3,056	2,929	-4%
Орлогын албан татвар	(166)	222	(502)	-3x
Цэвэр ашиг	737	3,277	2,410	-26%

Аудитлагдсан

Яагаад хөрөнгө оруулах вэ?

- Холдинг компанийн бүтцийн давуу байдал:** Ард Даатгал ХК нь Ард Санхүүгийн Нэгдэлийн эко системд байдаг нь синержи үүсгэх боломжтой болгож, бусад даатгалын компанитай харьцуулахад олон давуу тал үүсгэдэг бөгөөд тэр дундаа харилцагч шинээр татах болон харилцагчаа хэвээр хадгалахад хөшүүрэг болдог онцлогтой.
- Өсөн нэмэгдэж буй харилцагчийн суурь:** Ард Даатгал ХК өнгөрсөн онуудад харилцагчийн тоогоо хурдацтай нэмж 2019 онд 117,000 байсныг 2024 онд 256,512 болгосон нь 5 жилийн дотор харилцагчийн тоогоо 119% нэмэгдүүлсэн жишиг үзүүлэлт юм.
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлт:** Ард Даатгал ХК нь цахим хөгжлөөр салбартаа тэргүүлэгчдийн нэг бөгөөд цаашид хэрэглэгчдийн дата суурийг улам сайжруулж даатгалын үйлчилгээг хурдан шуурхай авах боломжийг бүрдүүлнэ. Мөн харилцагчдын дата суурийг хөгжүүлснээр цаашид бүтээгдэхүүний хөгжүүлэлтдээ харилцагчдын шаардлагыг илүү бодитоор тусгаж, харилцагчдад ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлнэ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАГЦ



2024 оны байдлаар Ард Даатгалын хөрөнгө оруулалтын багцын 20% нь Монголын Хөрөнгийн Биржийн хувьцаа, бонд болон Биржийн бус зах зээлийн бондоос бүрдэж байна. Харин үлдсэн 80% нь мөнгөний зах зээлийн хөрөнгө оруулалт байгаа ба хөрөнгө оруулалтын багцын өгөөж 2024 онд ₮3.3 тэрбумд хүрсэн нь өнгөрсөн оноос 5% өссөн дүн юм. Цаашид компани багцад эзлэх өндөр өгөөжтэй бүтээгдэхүүний хувийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын багцын өгөөжийг өсгөж ажиллана.

Хувьцаа

EPS IPO vs *Одоо 21.9 vs 82	BVPS IPO vs *Одоо 400 vs 780
P/E IPO vs *Одоо 32.03 vs 9.7	P/B IPO vs *Одоо 1.75 vs 1.03

* 2024.12.31 ны байдлаар